

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр, Мягмар гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-2

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 3-11

---

1. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын  
Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг хэлэлцэх 3-11

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
10 дугаар сарын 29-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Галбадрах, А.Ганбаатар, Г.Дамдинням, С.Эрдэнэбат;  
Чөлөөтэй: Г.Хосбаяр.

**Нэг.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын  
Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг хэлэлцэх**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлогын зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Боловсролын сайд П.Наранбаяр асуулгын талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, Б.Хэрлэн нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр хариулж, тайлбар хийв.

Асуулга асуусан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг сонслоо.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 28 минут үргэлжилж, 15 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 48 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим,  
12 цаг 20 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ч.Ундрэм:** Боловсрол, соёл,  
шинжлэх ухаан, спортын байнгын  
хорооны 2024 оны 10 сарын 29-ний  
хуралдааныг эхлүүлье.

Ирцийг та бүхэнд танилцуулъя.

Отгоншарын Батнайрамдал  
ирсэн байна. Дуламын Бум-Очир ирсэн  
байна. Шинэбаярын Бямбасүрэн ирсэн  
байна. Жанчивын Галбадрах чөлөөтэй,  
орон нутагт ажиллаж байгаа.  
Амгаланбаатарын Ганбаатар чөлөөтэй.  
Гонгорын Дамдинням чөлөөтэй.  
Бадрахын Найдалаа ирсэн.  
Цэндсүрэнгийн Мөнхтуяа ирсэн.  
Дүгэрийн Рэгдэл ирсэн. Отгоны  
Саранчулуун ирсэн. Мягмардашийн  
Сарнай ирээгүй байна. Чинбатын  
Ундрэм ирсэн. Ганбатын Хосбаяр  
ирээгүй байна. Бадарчийн Хэрлэн ирсэн.  
Сүхбаатарын Эрдэнэбат чөлөөтэй.

Ирц 60 хувьтай байгаа учраас  
хуралдаан эхэллээ.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

**Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын  
Ерөнхий сайдад хандаж тавьсан  
асуулгын хариуг хэлэлцэнэ.**

Энэ хэлэлцэх асуудалтай  
холбоотой материалыг та бүхэнд  
хүргүүлсэн байгаа, урьдчилж. Хэлэлцэх  
асуудал дээр өөр саналтай гишүүд байна  
уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий  
сайдад Ерөнхий сайдад хандаж тавьсан  
асуулгын хариуг Боловсролын сайд  
Наранбаяр танилцуулна. 8 дугаар  
микрофоныг нээе.

**П.Наранбаяр:** Эрхэм гишүүдийн  
энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол  
Улсын Их Хурлын гишүүн  
Ц.Мөнхтуяагаас 2024 оны 8 сарын 12-нд  
Ерөнхий сайд Оюун-Эрдэнэд ирүүлсэн  
Засгийн газрын 2014 оны 103 болон 104  
дүгээр тогтоолын хэрэгжилттэй  
холбоотой асуулгатай холбогдуулан  
бэлдсэн мэдээллийг та бүхэнд  
танилцуулъя.

Засгийн газрын 2024 оны 103  
дугаар тогтоол 24 оны 3 сарын 6-нд  
батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл  
нийтдээ 1379 суралцагчид 2 тэрбум  
367,6 сая төгрөгийн санхүүжилт олгож,  
6288 суралцагчдад 11 дүгээр сараас эхлэн  
14 тэрбум 600 сая төгрөгийн  
санхүүжилт олгохоор төлөвлөөд байна.

Энэхүү тогтоолоор батлагдсан  
журамд 6 төрлийн шаардлага хангасан  
багш мэргэжлээр суралцагч болон багш,  
ажилчдын хүүхдэд төрөөс дэмжлэг  
үзүүлэхээр заасан бөгөөд энэ чиглэл тус  
бүрээр олгосон дэмжлэг санхүүжилтийн  
мэдээллийг хүргүүлье.

1 дүгээрт, тус журмын 2.1.1 дэх  
хэсэгт заасан, Боловсролын ерөнхий  
хуулийн 12.2-т заасан ЕБС-ийн багш  
мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч  
чиглэлээр 2024-2025 оны хичээлийн жилд  
суралцаж буй сурагч одоогоор байхгүй  
бөгөөд журмыг нь боловсруулж байгаа  
болно.

2 дугаарт, журмын 2.1.2 дахь  
хэсэгт заасан багш бэлтгэх бакалаврын  
сургалтын үндсэн хөтөлбөрөөр  
суралцагч чиглэлээр 2024 оны 1-9 дүгээр

саруудад 657 суралцагчдад 1 тэрбум 146 сая төгрөгийн тэтгэлэг олгоод байна.

2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4434 суралцагчдад 9 тэрбум 48 сая 700 мянган төгрөгийг олгохоор тооцож байна.

Мөн Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 2.11 дэх заалтын дагуу багш мэргэжлээр өндөр оноотой суралцагчийн тэтгэлэгт үргэлжлүүлэн суралцаж буй 1069 суралцагчдад 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон.

Журмын 2.3.1.3 дахь хэсэгт заасан боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцах чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 19 суралцагчдад 22,5 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1062 суралцагчдад 2 тэрбум 172 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

Боловсролын 01 индексээр тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Хүснэгтэлсэн мэдээллийг та бүхэн харах байх.

4. Журмын 2.1.4 дэх хэсэгт заасан Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-д заасан хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 192 суралцагчдад 154,7 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 265 суралцагчдад 444,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон.

Хөдөө орон нутагт багш мэргэжлийн дадлагажигчийн тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд хүснэгтэлж хүргүүлсэн байгаа.

5 дугаарт, журмын 2.1.5 дахь хэсэгт заасан Боловсролын ерөнхий

хуулийн 12.10-д заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 88 суралцагчдад 155,4 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 736 суралцагчдад 1 тэрбум 591 сая 900 мянган төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон.

Бакалаврын хөрвөх сургалтын хөтөлбөрөөр тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд мөн хүснэгтэлж хүргүүлсэн байгаа. Энэ задаргаатай нь та бүхэн танилцаарай.

6 дугаарт, журмын 2.1.6 дахь хэсэгт заасан Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан багш, ажилтны 1 хүүхэд чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 233 суралцагчдад 552,8 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 673 суралцагчдад 2 тэрбум 692 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

Багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр суралцахад хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд мөн хүснэгтэлж хүргүүлсэн байгаа.

Боловсролын ерөнхий хуулийн 13.3.3 болон Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын хэрэгжилтийн талаарх мэдээлэл.

Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчид, үүнд: цэцэрлэгийн эрхлэгч, ЕБС-ийн захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, Албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид багтаж байгаа. Эхний 5 дахь жил болон дараагийн 3 дахь жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх

хэмжээний тэтгэмжийг тооцон олгож байна. Тэтгэмжид хамрагдаж чадахгүй байгаа албан хаагчдын нийтлэг үндэс хүслийг дурдъя. Үүнд:

1 дүгээрт, албан хаагч эхний 5 жил тасралтгүй ажилласан шаардлагыг хангамж тэтгэмж авсан ба дараагийн сар тасралтгүй ажилласан шаардлагыг хангахгүй, дундаа тасарсан байх тул журамд заасны дагуу зарим албан хаагч тэтгэмж авах шаардлага хангахгүй хасагдаж байгаа.

2 дугаарт, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхний 1 жил буюу 12 сар хүртэлх хугацааг тооцохоор журамд тусгасны дагуу тус шалгуураар зарим албан хаагч тэтгэмж авах шаардлага хангахгүй хасагдаж байгаа. Тус журмын 2.1.1-2.1.3-д заасан багш, ажилтан, сургалтын байгууллага хооронд сэлгэн болон шилжиж ажилласан бол тухайн хугацааг НДШ төлсөн лавлагаанд үндэслэн тасралтгүй ажилласанд тооцож, сүүлийн ажиллуулж байгаа байгууллага, албан тушаалын энэ журамд хамаарах нөхцөлөөр тэтгэмжийг тооцохоор журамласан байдаг. Зарим албан хаагч ижил түвшний сургалтын байгууллагад шилжин ажилласан боловч Боловсролын ерөнхий хуулийн 13.3.3-д заасан тэтгэмж авах албан тушаалд томилогдоогүй ба өөр албан тушаалд томилогдон ажиллаж байх тул тэтгэмж авах шаардлага хангахгүй хасагдаж байгаа. Үүний задаргааг та бүхэнд мөн хүснэгтэлж хүргүүлсэн. Энэ дээр ерөнхий боловсролын болон СӨБ-ын байгууллагын тус тус задалж харуулсан байгаа.

Танилцуулж дууслаа. Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Наранбаяр сайд аа, энэ маш олон нөгөө хүснэгтэлж, та бүхэнд харуулсан гээд тандалт судалгаа эд нар гээд энэ юмнууд нь байхгүй байна. Ямар ч хүснэгт бид нарт ирээгүй байна.

Тэгэхээр энэ хүснэгтийг та хэрвээ шаардлагатай гэж үзэж байгаа гишүүдэд яаралтай хувилаад хүргүүлмээр байна.

Танилцуулга дууссан учраас Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Боловсролын сайд Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунаа, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг, ЗГХЭГ-ын Салбарын бодлогын зохицуулалтын газрын дарга Мөнхцэрэн нар оролцож байна.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байвал нэрсээ өгнө үү. Нэрсийг нь авъя. Кнопоо дарна шүү. Асууж болно. Хамгийн сүүлд та дэгийн хуулиар бас үг хэлнэ. Үг хэлэнгээ асууж болно. Хамгийн сүүлд бас.

Хэрлэн гишүүнээр тасаллаа. Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын гишүүний зүгээс Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд 24 оны 8 сарын 12-ны өдөр тавьсан асуулгын хариуг хэлэлцэх нь гээд ингээд энэ юугаа би өөрөө бас товчхон бичээд ирсэн юм.

24 оны 3 сарын 6-ны өдрийн 103 дугаар тогтоолоор батлагдсан багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг эрэлттэй тэргүүлэх мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмын тухай. Энэ угаасаа хууль дээр байгаа шүү дээ. Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6 дээр байгаа. Тийм ээ, төрийн өмчийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежид 15-аас доошгүй

жил тасралтгүй ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд үнэгүй сургана гээд тийм ээ.

Энэ дээр болохоор ийм байна. Яамнаас ирсэн хариу. Боловсролын яамнаас ирүүлсэн хариуг үзэхэд 23-24 оны хичээлийн жилд нийт 673 багш, ажилтан хүүхдийнхээ сургалтын төлбөрийг чөлөөлүүлэх хүсэлт өгсөн байна. 673, үүнээс 233 хүүхэд нь л тэтгэмжид хамрагдсан. 233, 673-аас 233 шүү.

Хуульд тусгагдсан эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр суралцах 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх гэсэн шалгуураа давалгүй хасагдсан 264 ийм багш, ажилтан.

Журмын заалтаараа буюу магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг сонгосон байх гэсэн заалтаар 176 суралцагч энэ тэтгэмжээс чинь хасагдсан байна. Үндсэндээ 34 хувь нь тэнцээд, 66 хувь нь хасагдсан.

Үнэхээрийн харамсалтай тоо энд харагдаж байна л даа. Та нар болохоор нэг их өндөр их олон тэрбум төгрөг тавьчихсан гээд л, статистик мэдээ уншаад байдаг. Хачир дээрээ энэ хуулийн чинь энэ бас харгис хатуу заалтаас болж ийм олон хүүхдүүд сургуульдаа ингээд сурч чадахгүй, хасагдаж байна шүү дээ. Энэ дээр хэдүүлээ юу бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэдэг шиг ярилцах хэрэгтэй байгаа юм.

Энэ эрэлттэй тэргүүлэх тасралтгүй 15 гэдэг энэ тасралтгүй гэдэг үгийг энэ хуулиас хасах ийм заалтыг би нэмэлт, өөрчлөлтийг Ундрам гишүүн болон Бум-Очир гишүүнтэй хамтраад энэ хуулийн төсөл санаачилна. Нэмэлт, өөрчлөлт оруулна гэсэн ийм яриатай яваа.

2 дугаарт, нь энэ 34-хөн хувь нь л авсан байна шүү, энэ тэтгэмжийг чинь. Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6-д заагдсан энэ заалтыг анх хуулийн төсөл боловсруулах явцад Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооноос энэ санаачилга, саналыг анх оруулж байсан юм. Манай холбооныхон ярьж байгаад. Энэ ... /минут дуусав/

**Ч.Ундрам:** Дэгийн хуулиараа нөгөө асуулт асуух хугацаа нь 3 минутаас илүүгүй хугацаа байгаа шүү. Тэгэхдээ Мөнхтуяа гишүүн асуулга тавьсан гишүүн учраас хамгийн сүүлд дахиад асуулт тавьж, үг хэлж ингэж болно.

Хэрлэн гишүүн үг хэлнэ.

**Б.Хэрлэн:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Надад 2 асуулт байна.

Нэгдүгээрх нь, сая хөнгөлөлт эдэлж чадаагүй хүмүүсийн тодорхой нэг хувь нь магадлан итгэмжлэгддээгүй тийм сургуульд сурч байгаа учраас хөнгөлөлт эдлээгүй хасагдсан гэж байна, тийм ээ.

Тэгэхээр энэ дээр энэ өгсөн хариу дотор бичсэн байна л даа. 1.9-ийн дээх нь. Цаашид өмнөх жилд багш, ажилтны хүүхдүүд элссэн эсвэл элсэж сурч буй магадлан итгэмжлэгддээгүй хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана гэсэн ийм тайлбар өгсөн байна.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ маань нэг хэсэг хүмүүст юу гэдэг юм, хөнгөлөлт эдлүүлэхийн тулд тухайн хөтөлбөрийг нь магадлан итгэмжлэх хэрэгтэй болоод байна гэсэн үг үү? Нэг хэсэг хүмүүсийн хэрэгцээнд зориулаад, тэр хүмүүст хөнгөлөлтийг эдлүүлэхийн тулд тухайн сургалтын хөтөлбөрийн агуулга тийм ээ, сургалтын орчин нь ямар байхаас үл хамааран магадлан итгэмжилье гэсэн ийм бодлогыг Боловсролын яамнаас таны яамнаас

баримтлаад байна гэсэн үг үү? Энэ өөрөөр хэлэх юм бол нөгөө боловсролын чанарын тухай асуудалд энэ хэр нийцэж байгаа юм гэж би 1 дүгээрт, асуумаар байна.

2 дугаарт, нь багш мэргэжлээр сурч байгаа, багш мэргэжлээр төрөөс тодорхой хэмжээний бас тэтгэмж аваад, тэтгэлэг аваад багш мэргэжлээр бакалавр, магистрын сургалтад сурч байгаа олон хүн байгаа. Тэгэхээр энэ яг энэ тайлбартай холбоогүйгээр би зүгээр нэг бас зүйлийг асууя гэж бодож байна.

Тэгэхээр энэ багшийн мэргэжлээр төрөөс нөгөө сургалтынхаа төлбөрийг даалгаад сурч байгаа хүмүүсийг цаашид төрдөө эргээд буцаагаад нөгөө өгөөжөө өгөх, тийм ээ. Тухайн яг ажил, мэргэжлээр нь ажиллуулах тухай дээр танай яамнаас ямар бодлого баримталж байгаа вэ?

Дээр нь багш мэргэжлээр ажиллаж байгаа хүмүүсийн хүүхдүүдийг бас ингээд сургах юм байна. Сургасныхаа дараагаар тэд нарыг яг тухайн эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээл дээр ажил хөдөлмөр эрхлээд явах тийм бас хариуцлага хүлээж ажиллах талаас нь та нар ямар бодлого баримтлах вэ гэж би асууж байна. Ийм 2 асуулт байна.

**Ч.Ундрам:** Эхлээд Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Наранбаяр сайд 8 дугаар микрофон.

**П.Наранбаяр:** Тэгэхээрээ 673 хүүхдийн асуудал яг яригдсан. Тэгээд 233 нь аваад 34 хувь нь аваад, бусад нь аваагүй нь бодитой тоо. Тэгэхээр энэ дээр яг энэ нөгөө журмын үндэслэл хэсэг дээр нь тэр 15 жил дээрээ тасралтгүй ажилласан гэдэг дээрээ унасан хүмүүс бий. Үнэхээрийн харамсалтай. Яахын аргагүй тэр хуулийн заалтаараа ингээд ороод ингээд явчихсан учраас, хууль байгаа учраас, хууль дээр өөрчлөлт ороод ингээд заавал үүнийг хатуу мөрдөхгүй, яг багшаар ажиллаж байгаад ингэсэн бол

гэвэл энэ яг хэрэгжээд явах бүрэн боломжтой гэж харж байгаа.

Нөгөө тал дээрээ бас тэр эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн энэ чиглэлээр сурч байгаа хүүхэд гээд ингэхээр өөр чиглэл байхаар бид яаж ч чадахгүй ингээд хассан тохиолдол бий. Яг 9 дүгээр сард эхлээд энэ магадлан итгэмжлэлийн асуудал бас яригдсан. Магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөр байна шүү дээ. Эрэлттэй тэргүүлэх болов чиг магадлан итгэмжлэгдэж амжаагүй байна гэсэн ийм асуудал үүссэн учраас үүнийг нь бид нар харин өөрсдийнхөө хүрээнд энэ магадлан итгэмжлэлийг хурдан гарга гэж шахаж байгаа. Тэгээд энэ магадлан итгэмжлэл чинь өөрөө дандаа эрэлттэй тэргүүлэх чиглэлүүд дээр байхгүй юу даа.

Тэгэхээр үүнийг зайлигүй хийх шаардлагатай учраас энэ магадлан итгэмжлэл хийхийг бид нар шахаж ингэж ажиллаж байгаа. Яг энэ үндэслэлээр хасагдсан хүн байхгүй. Энэ үндэслэлээр бид яг эрэлттэй тэргүүлэх чиглэл мөн байгаад байдаг. Тэгээд магадлан итгэмжлэлд хараахан амжаагүй эсвэл магадлан итгэмжлэх ажил нь явцын дундаа байгаа ийм мэргэжлүүд рүү явсан энэ хүүхдүүдийг бүгдийг нь өргөдлийг нь хүлээж авч, цохолтын аргаар шийдсэн байгаа шүү. Ийм байдалтай байгаа.

Тэгэхээр аль аль талдаа бас ажлаа уялдуулж явах ийм шаардлага байгааг бид харж байгаа.

Хэрлэн гишүүний хэлсэн үнэн. Бид бас энэ дараагийнх нь Хэрлэн гишүүний асуултад хамт хариулчхаж болох уу? Тийм ээ. Тэгэхээр Хэрлэн гишүүний хэлээд байгаа нь үнэн. Тэр ер нь эрэлттэй тэргүүлэх мэргэжил учраас ер нь магадлан итгэмжлэх учиртай гэсэн ийм бодлого барьж байгаа. Харин ингээд тэтгэлэг авч сурчхаад яг багшаар нь ажиллуулах асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ гээд, энэ чинь дотроо



журмаараа шийдчихсэн байгаа. Яг зарим хэсэг нь яг орон нутагтаа багшлах багш нар байгаа шүү дээ тийм ээ. Яг ийм үндэслэлээр авч байгаа ч ийм тэтгэлгүүд байгаа.

Тэгэхээр энэ гэрээнийхээ дагууд явна. Яг тэр заасан журмынхаа дагууд явна.

Урьд нь бас нэг гашиун туршлага бий. 2013 оноос билүү эхэлсэн 800 оноо дөхүүлж авсан, 700-аас дээш оноо авсан ийм хүүхдүүдийг МУБИС дээр 100 хувийн тэтгэлэгтэй 70-100 хувийн тэтгэлэгтэй ингэж бэлдчихээд, тэгээд эргээд харсан чинь тэдний 40-хөн хувь нь багш болсон. 60 хувь нь яваад өгчихсөн. Тэгэхээр энэ дээр энэ сургамжаасаа бид энэ сургамжаа судлаад, тэгээд яг л багшилж байж энэ олгосон боловсролын энэ тэтгэлэг чинь яг буцалтгүй болж хувирна шүү гэдгийг энэ журамдаа тусгачихсан байгаа. Зарим нь бүр орон нутагтаа очиж багшлахыг нөхцөл болгосон ийм байдалтай байгаа. Энэ болохоороо зэрэг 6.2.3 манай 6.2.3 дээр байгаа. Тэгээд ... /минут дуусав/

**Ч.Ундрэм:** Наранбаяр сайдад дахиад 3 минут өгье. 2 хүний асуултад хариулж байгаа учраас.

**П.Наранбаяр:** Тэгээд цаашидаа бид ер нь энэ ямар бодлого барих вэ гэхээр ер нь энэ тэр эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийг аль болохоор эртхэн тогтоож, эртхэн хүмүүс зарлахгүй бол гэнэт гэнэт өөрчлөгдөөд байгаа. Ер нь нийгмийн амьдрал өөрөө хурдтай яваад байгаа учраас мэдээгүй байсан. Ноднин жил гэхэд энэ чинь эрэлттэй мэргэжилд орчихсон гэсэн ийм гомдол их ирж байгаа. Энэ бол төр талаас мэдээллээ хүргэхэд бид анхаараагүй бидний алдаа гэж харж байгаа.

Тийм учраас бид бас энэ эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийг тогтоох чиглэлээр Төрийн албаны зөвлөлтэй эд нар хамтраад бас нэг ийм

хамтарсан ийм яриа хэлцэл явуулж байна. Түүнээс гадна яг энэ эзэмшсэн, тийм саяын энэ журмын би яг холбогдох заалтыг нь уншаад өгье.

6.2.3 дээр багш бэлтгэх бакалавр, магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцаж төгсөөд, төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад орон нутагт 3-аас доошгүй жил, эсвэл нийслэлд 5-аас доошгүй жил тогтвортой ажиллах гээд маш сайн заачихсан байгаа. Тэгж байж, энэ гэрээ байгуулах энэ заалтын нэг хэсэг нь болоод орчихсон учраас цаашидаа багш нар бас яг энэ тэтгэлгээ авч сурчхаад, тэгээд буцалтгүй олгох ийм боломжтой болж ирж байгаа гээд. Эрэлттэй тэргүүлэх мэргэжлүүдийг ингэж эртхэн зарладаг болох.

Тэгээд яг тухайн эзэмшсэн мэргэжлээрээ хүн яг ажиллаж байна уу, үгүй юу гэдгийг мөрдөх судалгаа хийхэд энэ нөгөө сургуулиудын их, дээд сургуулиудын эрэмбийг тогтоох бас нэг чухал үзүүлэлтийн нэг болж байгаа. Энэ судалгаандаа өөрсдөө орж ирж байгаа.

Тэгэхээр зэрэг тухайн сургуулийг их сургуулийг бас нэг үнэлэх гол үнэлгээний нэг нь яг мэргэжлээрээ бэлдсэн хүнээ мэргэжлийнхээ яг зах зээл дээр оруулж ирж байна уу, үгүй юу гэдэг бас нэг чухал үзүүлэлт байгаа.

Түүнээс гадна Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай ярилцаад бид дундын нэг ийм платформ хийж байгаа юм. Энэ дээр яг ингээд бэлтгэгдсэн хүмүүс хөдөлмөрийнхөө зах зээл дээр уялдаж байна уу, үгүй юу гэдгийг нь харах ёстой. Энэ 12 дугаар сарын сүүлээр дуусна. Энх-Амгалан сайд, Боловсролын сайд миний бие ингээд хамтраад хийж байгаа хамтын ажлын хэсэг нь гараад хийгдэж байгаа ийм ажил байгаа юм. Энэ Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд туссан ийм ажил байгаа. Баярлалаа.

**Ч.Ундрэм:** Хариулт дууссан уу, тийм ээ. Өөр нэмж хариулах хүн байхгүй.

Ер нь бид нар өмнөх парламентад Боловсролын багц хуулийг шинэчлэхдээ энэ Багш нарын нийгмийн баталгаа гэсэн дэд бүлгийг Багш нарын үйлдвэрчний холбоотойгоо хамтраад, ярилцаад энэ бүлгийг шинээр Боловсролын хуульд оруулж өгсөн байгааг та бүхэн мэдэж байгаа.

Тэгээд үүний гол зорилго нь багш нараа бид нар тогтоон барих, нийгмийн баталгааг нь ядаж энэ хүрээнд ч гэсэн хангах ийм зорилгоор энэ заалтуудыг оруулж ирсэн байгаа.

Тэгэхээр энэ заалтыг хэчнээн оруулсан ч гэсэн багш нар маань зөвхөн хүсэлт өгсөн хүмүүсийн 34 хувь нь л авч чадсан гэдэг чинь маш бага хувь хэмжээ гэдэг дээр бүгдээрээ санал нийлж байгаа байх гэж бодож байна.

Тийм учраас Мөнхтуяа гишүүн санаачлаад, бид нар дэмжээд, бас энэ хатуу заалтуудыг арай зөөлрүүлж өгье өө. Багш нараасаа бас судалгаа аваад, үүнийг илүү боломжийг нь нээж өгье. Яагаад гэвэл нөгөө гол зорилгоо бүрэн биелүүлж чадахгүй байна, энэ заалт гэж үзэж байгаа учраас хуулийн төсөл санаачлах бэлтгэл ажилдаа ороод ингээд явж байгаа.

Тэгэхээр ийм хууль өргөн баригдана. Энэ хугацаанд бас яамнаас энэ тэргүүлэх мэргэжлүүдээ эртхэн зарлая гээд ингээд аль болохоор уян хатан хандах гээд ажиллаж байгаад баяртай байна.

Хэрлэн гишүүн бас их чухал асуулт асуулаа. Эргээд энэ бас тэтгэлэг авсан хүүхдүүд маань ажлын байртай байх ёстой. Мөн төрөөс нэгэнт татвар төлөгчдийн мөнгөнөөс тэтгэлэг авч байгаа юм чинь эргээд төрдөө ажиллах, ялангуяа энэ багш мэргэжлээр сурч

байгаа хүүхдүүд багшлах, орон нутагтаа багшлах гэдэг маш чухал. Эргээд бас энэ чинь үүрэгтэй байх ёстой.

Тэгэхээр энэ дээр бас орон нутагт ажиллуулах нөхцөлийг гэрээнд нь тавьж байгаа гэж ойлголоо, тийм үү.

Ингээд дэгийн тухай хуулийн 113.1.2-т холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулгатай холбоотой өөр асуулт асуух гэж заасны дагуу Мөнхтуяа гишүүнд 5 минут өгье.

**Ц.Мөнхтуяа:** Баярлалаа. Сая Ундрэм гишүүн хэлж байна, тийм ээ. Манай Багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооноос анх энэ заалт санаачилж, Боловсролын ерөнхий хуульд оруулж байсан юм. Тэгээд энэ заалт маань хатуу болсон учраас бид нар бас ярилцаад нэр бүхий гишүүд энэ дээр шинэ хуулийн төсөл санаачилна гээд сая Ундрэм гишүүн хэлчихлээ.

Дараагийн асуудал. Нөгөө магадлан итгэмжлэлийн асуудлыг бас ярьчихлаа. Магадлан итгэмжлүүлэх нь өөрөө сургуулийнх нь асуудал байдаг байх, тийм үү? Сургуулийнхаа сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх. Энэ магадлан итгэмжлүүлээгүйгээс болж хасагдана гэдэг бол эмгэнэлтэй шүү дээ. Тэр хүүхдийн тэр эцэг, эхийн буруу биш.

Тийм учраас энэ асуудал дээр бас Наранбаяр сайд аа, сайн анхаарч ажиллаарай гэж хэлье.

Сая мэдээж Ундрэм гишүүнтэй санал нэг байна. 15 жилээс тасралтгүй гэдэг үгийг л хасъя гээд байгаа юм, манай багш нарын санаа. Тэгэхээр хүний амьдрал баян шүү дээ. Өвчтэй, зовлонтой, амьдрал ахуйгаа бас нэг банкныхаа өр зээлийг дарах гээд Солонгос явдаг тийм ээ, нэг 3 сар явж ирээд л ингээд л энэ нь ажил нь

тасарчихсан болоод л нөгөө багш маань тэтгэлэгтээ хамрагдаж чадахгүй ийм юмнууд маш их байгаа учраас багш нараас ирсэн энэ гомдол, саналыг л оруулж байгаа юм шүү. Тэрнээс би өөрөө дураараа зохиогоод яриад байгаа юм энд нэг ширхэг ч байхгүй.

Тэгэхээр энэ эрэлттэй, тэргүүлэх мэргэжил гэдгийг хасаад тасралтгүй гэдгийг хасах юм бол багийн хомсдолоос бас бага ч гэсэн гарах боломж гарна гэж сая Ундрэм гишүүн хэлж байна шүү дээ. Жишээ нь, 10 жил ажиллаад Солонгос гарчихсан хүн буцаж ирээд 5 жил ажиллаад энэ тэтгэмжид хамрагдах жишээний тийм ээ. Одоо энэ 40 хувь нь ажилласан гэж сая Наранбаяр сайд хэллээ шүү дээ, нөгөө улсын зардлаар сураад. Энэ чинь нөгөө залуучууд цалингаа голоод л энэ багийн мэргэжлээс дайжаад айгаа шүү дээ. Хамгийн гол шалтгаан чинь энэ байхгүй юу. Ажиллахгүй байгаадаа биш, ерөөсөө л цалин хөлс, нийгмийн баталгаа нь хангалтгүй байгаа учраас залуу багш нар энэ ажлыг хийхгүй байна. Төгсчөөд хаяад явж байна. Энэ дээр л төр засаг минь онцгой анхаараач гэж 7, 8 жил ярьж яваа шүү дээ.

2 дугаар асуудал. Монгол Улсын Засгийн газрын 24 оны 3 сарын 6-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль, коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журмын тухай. Энэ журмын хүрээнд ганц л заалт асуудал гомдол дагуулаад байгаа юм. Тэр нь ямар заалт вэ гэхээр журмын 2 дугаар зүйлийн 2.3.7-д жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхний 1 жил, 12 сар хүртэл хугацааг тасралтгүй ажилласанд тооцно оо гээд байгаа юм. Наранбаяр сайд аа, энэ заалт. Энэ өмнө нь 6 сар байж байгаад бөөн хэл ам дагуулаад 12 болсон юм. Энх-Амгалан сайдын үед. Энэ 12 сарыг 24 болгох боломжийг хэдүүлээ

хайя. Бид нар дандаа болохгүй, болохгүй, бүтэхгүй, хуульд ингэж заасан гэж ярьдгаа жоохон болимоор байна. Хүн рүүгээ чиглэсэн, хүндээ ээлтэй ийм хуулийн заалтууд оруулж ирэхгүй бол дандаа нэг хахир хатуу, хүндээ ээлгүй ийм нэг хуулийн заалтууд оруулж ирээд, тэгээд энэ хуулиа дагаж мөрдөнө гээд ингээд чичрээд суугаад байж болохгүй гэж бодож байна.

Тийм учраас энэ 12 сарыг 24 сарын болгож өөрчилмөөр байна. Яагаад гэхээр Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1-д байгаа шүү дээ. 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээрээ зохицуулна гээд заачихсан байгаа.

Тэгэхээр үүнийг бид нар 24 сар болгох боломж Засгийн газарт байгаа шүү гэдгийг Наранбаяр сайддаа бас дуулгая, тийм. Хэдүүлээ дандаа нэг болохгүй гэдэг үгнээсээ жоохон өөрчилье. Манай энэ парламент чинь 81 бараг шинэ гишүүн байгаа гэж би сонссон. Тэгэхээр энэ шинээр харж байгаа, шинээр сэтгэж байгаа, шинэ гишүүддээ бас би уриалмаар байна. Хуучин чинь ч гэсэн 2, 3 гарсан сайн ажилладаг гишүүд байгаа шүү дээ. Манай Ундрэм гишүүн боловсрол дээр нэлээн сайхан дуу хоолой болоод явж байгаа ийм мундаг эмэгтэй байгаа.

Тэгэхээр би Ундрэм гишүүнийг энэ дээр бас нэлээн хүч өгөөд анхаарал хандуулаарай гэдгийг бас Боловсролын байнгын хороон даргын хувьд бас хэлчихмээр байна. Ундрэм гишүүнд бас захиасаа өгч байна шүү дээ.

Ийм байна. Болчихсон.

**Ч.Ундрам:** Асуултаа асууж,  
хариулт авч дууслаа.

Тэгээд цаашид манай Боловсролын  
яам бас сая 2 Улсын Их Хурлын гишүүний  
асуусан асуулт, мөн хэлж байгаа үгийг  
маш сайн анхаарч, цаашидынхаа ажилд  
тусгаад, аль болохоор уян хатан явах  
хэрэгтэй байх.

Бид нарын хамгийн том салбарын  
асуудал ерөөсөө багшийн хомсдол байгаа.  
Тэгэхээр багш нартаа аль болохоор  
хамгийн ээлтэй ажиллах орчныг бий  
болгож, нийгмийн баталгааг нь хангах  
тал дээр анхаарах ёстой. Чадахаасаа  
чадахгүйгээ хүртэл ингэж зүтгэх ёстой  
гээж бодож байгаа.

Ингээд хэлэлцэх асуудал дууссан  
учраас хуралдаан хаалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ